



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/185

Мөрөн сум

Төсөвт өртгийн дээд хязгаар
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.6, 65 дугаар зүйлийн 65.1.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит XVI хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сан дахь “Зураг төсвийн сан”-аас санхүүжүүлэх шинээр барих, засварлах, шинэчлэх барилга байгууламжийн ажлын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг 1 дүгээр, инженер геологийн дүгнэлт гаргах зөвлөх үйлчилгээний төлбөрийн төсөвт өртгийн дээд хязгаарыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төсөл арга хэмжээний зураг, төсвийг боловсруулах зөвлөх үйлчилгээ нийлүүлэх гүйцэтгэгч сонгож гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог), сумын Засаг дарга, агентлаг байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

3. Төсөл арга хэмжээнүүдийн зураг төсвийн үнийг хавсралтад заагдсан эх үүсвэрээс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа) нарт тус тус даалгасугай.

4. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Хөвсгөл аймагт хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зураг, төслийн даалгавар, техникийн нөхцөл, техникийн тодорхойлолт зэрэг холбогдох баримт бичгийг бэлтгэн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа), сумын Засаг дарга, агентлаг байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

6712010143

Аймгийн Засаг даргын 2023 оны 04
дугаар сарын 25-ны өдрийн
А/185..дугаар захирамжийн 1 дүгээр
хавсралт

АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН ДАХЬ “ЗУРАГ ТӨСВИЙН САН”-ААС
САНХҮҮЖҮҮЛЭХ ШИНЭЭР БАРИХ, ЗАСВАРЛАХ, ШИНЭЧЛЭХ, БАРИЛГА
БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТӨЛБӨРИЙН ТӨСӨВТ ӨРТГИЙН ДЭЭД ХЯЗГААР

№	Арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	тайлбар
1	Бүрэнхаан сургуулийн баруун талын хатуу хучилттай авто замыг нэвтрэх инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл боловсруулах	15,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
2	Хатгал тосгоны цэцэрлэгийн барилгын дотор, гадна их засварын ажлын зураг төсөл боловсруулах	11,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
3	Мөрөн сумын 4,5,7,9,10,11-дүгээр багийн гэрэлтүүлэггүй байгаа гудамжнуудад гэрэлтүүлэг шинээр хийх ажлын зураг төсөл боловсруулах	5,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
4	Кассын байр бүхий ариун цэврийн байгууламжийн өргөтгөл болон гадна тохижилт, гадна инженерийн шугам сүлжээний нэмэлт ажлын зураг төсөл боловсруулах	5,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
5	Мөрөн сумын Угтах, үдэх хаалга орчмын тохижилтын ажлын зураг төсөл боловсруулах	4,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
	Нийт дүн	40,000,000	

Аймгийн Засаг даргын 2023 оны 04
дүгээр сарын 25-ны өдрийн
0/185-дугаар захирамжийн 2 дугаар
хавсралт

АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН ДАХЬ “ЗУРАГ ТӨСВИЙН САН”-ААС
ИНЖЕНЕР ГЕОЛОГИЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТӨЛБӨРИЙН ТӨСӨВТ ӨРТГИЙН ДЭЭД ХЯЗГААР

№	Арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	тайлбар
1	Мөрөн сумын 2 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн /150 хүүхэд/ барилгын инженер геологийн дүгнэлт	3,300,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
2	Мөрөн сумын 6 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн /150 хүүхэд/ барилгын инженер геологийн дүгнэлт	3,300,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
	Нийт дүн	6,600,000	